# НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 15 өдөр | Дугаар А/1286 | Улаанбаатар хот

Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл хийх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.4, 8.1.5, 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэг, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны “Журам батлах тухай” А/479 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Агаарын бохирдлын эх үүсвэрийн бүртгэл, тооллогын ажлыг жил бүрийн 11 дүгээр сарын 01-нээс дараа оны 03 дугаар сарын 15-ны хооронд удирдан зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ахлагч: Нийслэлийн Агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан төслүүдийн удирдагч

Гишүүд:

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга;

Нийслэлийн Байгаль орчны газрын дарга;

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дарга;

Нийслэлийн Тээврийн газрын дарга;

Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын дарга;

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын инженерийн байгууламжийн хэлтсийн дарга;

Багануур дүүргийн Засаг дарга;

Багахангай дүүргийн Засаг дарга;

Баянгол дүүргийн Засаг дарга;

Баянзүрх дүүргийн Засаг дарга;

Налайх дүүргийн Засаг дарга;

11102000б298

Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга;

Сүхбаатар дүүргийн Засаг дарга;

Хан-Уул дүүргийн Засаг дарга;

Чингэлтэй дүүргийн Засаг дарга;

| | |
|---|---|
| Нарийн бичгийн дарга: | Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын дарга |

2. Агаарын бохирдлын эх үүсвэрийн бүртгэл, тооллогын ажлын удирдамжийг батлан, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор тайлагнаж ажиллахыг Нийслэлийн Агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан төслүүдийн удирдагч /З.Төмөртөмөө/-д үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ Д.СУМЪЯАБАЗАР